



GOLOMT BANK
Investing for a brighter future

The best
**Corporate
Banking**
in Mongolia

ШИЛДЭГ САНХҮҮЧДИЙН ШИРЭЭНИЙ НОМ

Монгол Улсын эдийн засгийн цохилох зүрх хөгжлийг түүчээлэгч аж ахуйн нэгжийн удирдлага, шилдэг санхүүч та бүхний энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье!

Бизнесийн талбарт шинэчлэлтийг эхлүүлэхэд гол нөлөө үзүүлэх манлайлагч та бүхэнд зориулан Голомт банкны шинжээчдийн бэлтгэсэн 2022-2023 оны макро эдийн засгийн төлөв байдлын талаарх судалгаа, мэдээллийг хүргэж байгаадаа таатай байна.

Та энэхүү номоос голлох түүхий эдийн зах зээлийн нөхцөл байдал, цаашдын хандлага, цар тахал болон дайн, түүний эсрэг хэрэгжүүлж буй сангийн болон мөнгөний бодлого, түүнчлэн бодит эдийн засгийн өсөлт, түүхий эдийн зах зээл, мега төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжтой юм.

Мэдээлэлтэй хүн илүү олон боломжийг олж хардаг. Бидний өгч буй мэдээллийг та өөрийн туршлагатай хослуулан өнгөрснөөс илүү сайхан ирээдүйг бүтээж чадна гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон харилцагч таны шийдвэр мэргэн байг.

Хүндэтгэсэн:



З.Мягмардорж
Байгууллагын банкны газрын захирал

АГУУЛГА

Бүлэг 1. ОЛОН УЛСАД ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Орос Украины дайн
- Инфляцын өсөлт, эдийн засгийн бууралт
- Стагфляцын үзэгдэл

Бүлэг 2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Эдийн засгийн өсөлт
- Инфляц, мөнгөний бодлого
- Гадаад худалдаа

Бүлэг 3. ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУД

- Уул уурхай
- Худалдаа
- Үйлчилгээ
- Үйлдвэрлэл
- Барилга
- Тээвэр

Бүлэг 4. ЭДИЙН ЗАСГИЙН ИРЭЭДҮЙН ТААМАГЛАЛ

- Суурь таамаглал
- Эдийн засагт учирч болзошгүй эрсдэлүүд
- Нэгтгэл

Бүлэг 5. ТЭЭВРИЙН САЛБАРЫН СУДАЛГАА

- Тээврийн салбар ба эдийн засаг
- Тээврийн салбар ба бусад эдийн засгийн салбарын уялдаа холбоо
- Авто замын тээвэр
- Төмөр замын тээвэр

Бүлэг 6. ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

- Тогтвортой, ногоон бизнесийн зээл
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл
- И-Биллинг үйлчилгээ
- Данс автоматжуулах үйлчилгээ
- Корпорэйт гэйтвэй



1


ОЛОН УЛСАД
ЭДИЙН ЗАСГИЙН
НӨХЦӨЛ
БАЙДАЛ

ОРОС УКРАИНЫ ДАЙН

2022 оны 2-р сарын 24-ны өдөр Украины нутаг дэвсгэрт Оросын цэргүүд довтлон орж ирснээр Орос Украины дайн эхэлсэн билээ. Ийнхүү Ковидын дараах дахин нэг хүч сорьсон давлагаа эдийн засагт тулгарч энэхүү дайны нөхцөл байдал дэлхийн ихэнх орны эдийн засагт хүндээр нөлөөлж бодлого боловсруулагчдын өмнө томоохон сорилтыг авчирлаа.

2019 оны эцсээс Ухань хотоос эхлэлтэй коронавирус дэлхий даяар тархан өдгөө гурван жилийн нүүрийг үзээд буй. Ковид гарснаас хойших нэг жилийн хугацаанд дэлхийн өнцөг булан бүрд эдийн засгийн уналт явагдаж, үйлдвэрлэл зогссон, ядуурал нэмэгдсэн үзэгдэл ажиглагдав. 2021 оноос эхлэн эдийн засгийн өсөлт явагдаж 2022 онд дэлхийн эдийн засгийн өсөлт өндөр байхаар таамаглагдаж байсан ч Орос Украины дайны нөхцөл байдал дэлхийн эдийн засгийн өсөлтийн хандлагыг эсрэг зүгт хөтлөв. Аль хэдий нь хямралд өртсөн дэлхийн эдийн засагт дайн гарснаар байдлыг улам хурцатгаж инфляцын түвшин өндөр, нөгөө талаас эдийн засгийн өсөлтийн хурд удаашрах үзэгдэл ажиглагдаж байна.

Нийт дэлхийн экспортод эзлэх хувь




Эх сурвалж: Дэлхий банк

Орос улс нь дэлхийн хамгийн том улаан буудай, ширэм, байгалийн хий, никель экспортлогч бөгөөд нүүрс, газрын тос, хөнгөн цагааны экспортын ихээхэн хувийг эзэлдэг. Орос, Беларусь зэрэг улсууд нь бордооны чухал экспортлогчид бол Украин нь улаан буудай, наранцэцгийн тос зэрэг хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийн гол экспортлогч орон юм. Орос улс нь 2021 оны байдлаар байгалийн хийн экспортын 25.2 хувь, газрын тосны 11.5 хувийг дангаар хангадаг бол Орос, Украин нийлээд үр тариан нийт экспортын 28.2 хувийг хангадаг. Тэр утгаараа ХАА болон эрчим хүчний түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ Орос Украин улсын экспортын нийлүүлэлтийн хэмжээнээс ихээхэн хамааралтай. Тиймээс ч эдгээр хоёр орны хоорондын дайн бусад улс орнуудын импортын бүтээгдэхүүний үнэд шууд нөлөөлөл өндөртэй байна.

Оросын эсрэг тавьсан хориг арга хэмжээ, тухайлбал SWIFT-н хязгаарлалт нь Орос болон барууны орнуудын худалдааг тасалдуулж, энэ нь эргээд дэлхийн бусад орнуудад, дан ялангуяа барууны орнуудад эрчим хүчний үнэ огцом өсөх шалтгаан болжээ.

Түүхий эдийн үнэ /өдрөөр/



Эх сурвалж: Блүүмберг Терминал

Дайнаас шалтгаалсан худалдааны тасалдалд Европын Холбоо болон хөгжиж буй улс орнууд хамгийн ихээр өртөж байна.


Европын Холбоо нь байгалийн хийн 35 хувь, газрын тосны 20 хувь, нүүрсний 40 хувийг Оросоос импортлодог. Хариуд нь Орос улс экспортынхоо хувьд Европын Холбооноос хамааралтай бөгөөд шатахуун, байгалийн хийнхээ 40 орчим хувийг Европ руу экспортолдог. Мөн олон хөгжиж буй улс орнууд Орос Украины хүнсний хангамж болон эрчим хүчний түүхий эдүүдээс ихээхэн хамаардаг. Тиймээс дайнтай холбоотой түүхий эдийн үнийн өсөлт импортлогч улсад хор хөнөөл өндөртэй байгаа бол экспортлогч орон болох Оросын хувьд ч түүхий эдээ гадаадын зах зээлд борлуулж чадахгүй байх хүндхэн нөхцөл байдлыг авчраад буй.

Канад, Европын Холбоо, Япон, Их Британи, АНУ зэрэг хэд хэдэн улс ОХУ-аас бүр мөсөн эсвэл хэсэгчлэн эрчим хүчний бүтээгдэхүүн импортлохоо хориглож, үе шаттайгаар зогсоож байгаагаа зарласан. Хэд хэдэн томоохон газрын тосны компаниуд Орос дахь үйл ажиллагаагаа зогсооно гэж мэдэгдсэн бол олон бизнес эрхлэгчид Оросын газрын тосыг үйл ажиллагаандаа ашиглахаа зогсоосон. Үүний үр дүнд Уралын үнэ (Оросын газрын тосны үнэ) дайн эхэлснээс хойш Brent газрын тосны үнээс баррел тутамдаа 30 гаруй доллараар бага байна.

Түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан дэлхийн ихэнх улс орнуудад инфляц таамаглалаас давж өндөр түвшнээр өсөв.

ИНФЛЯЦЫН ӨСӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БУУРАЛТ

Сонгогдсон орнуудын жилийн инфляц,
2022 оны 8-р сарын байдлаар



Эх сурвалж: ОУВС, Дэлхий Банк

Сонгогдсон бүх томоохон улс орнуудын хувьд дайны дараа инфляц өсөх хандлагатай байна. 8-р сарын байдлаар АНУ-д инфляцын түвшин 8.3 хувьтай буюу сүүлийн 40 жилийн хугацаан дах хамгийн өндөр түвшиндээ хүрээд буй. ОХУ-н инфляцын түвшин 8-р сард 14.3 хувьтай, Хятад улс харин 2.5 хувьтай гарсан бол Монгол улсын хувьд 14.4 хувьтай гарсан байна. Дэлхий даяар улс орнуудад инфляцын түвшин дайны өмнөх үед таамаглагдаж байсан хэмжээнээс дээгүүр байгаа бөгөөд улс орон бүрийн бодлого боловсруулагч нар инфляцын түвшинг зорилтот хэмжээнд барьж тогтоох зорилгоор мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлж байгаа ч таамаглагдаагүй байсан дайны шок бодлогын цар хүрээг багасгаж байна.

Олон улсад эдийн засгийн нөхцөл байдал

Олон улсад эдийн засгийн нөхцөл байдал

Саарал-Нэгдүгээр сарын таамаглал, Цэнхэр-Долдугаар сарын таамаглал

Дэлхийн ЭЗ-н өсөлт




Монголын ЭЗ-н өсөлт



АНУ-н ЭЗ-ийн өсөлт



Хятад-н ЭЗ-н өсөлт



Орос улсын ЭЗ-н өсөлт



Эх сурвалж: ОУВС

Дайн гарахаас өмнө буюу 2022 оны 1-р сард ОУВС-с гаргасан тайланд дурдсанаар дэлхийн эдийн засгийн өсөлт 2022 онд 4.4 хувь байхаар таамаглагдаж байсан бол 7-р сард гарсан шинэчилсэн тайланд 3.2 хувь болж нийт 1.2 пунктээр буурчээ. Томоохон улс орнуудын хувьд ч мөн эдийн засгийн өсөлтийн таамаглал тус бүр буурсан байна. 2022 оны 1-р сард гаргасан таамаглалын дагуу АНУ-н эдийн засгийн өсөлт 2022 оны эцсээр 4 хувьтай, 2023 онд 2.6 хувьтай байсан ч 7-р сарын таамаглалаар энэ тоо буурч 2.3% болон 1% байхаар гарчээ. Хятад улсын хувьд ч мөн адил оны эцсээр 4.8 хувийн эдийн засгийн өсөлттэй байхаар таамаглагдаж байсан ч энэ тоо буурч 3.3 хувь болсон байна. ОХУ-н хувьд дайнтай холбогдуулан дайны өмнөх таамаглалаас ихээр буурч 2.8 хувийн өсөлттэй таамаглагдаж байсан эдийн засгийн өсөлт 7-р сарын тайланд -6.0 хувийн бууралттай байхаар гарч нийт 8.8 пунктийн бууралтыг үзүүлжээ. Ийнхүү эдийн засгийн өсөлтийн таамаглал буурсанд хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн ба эдгээр нь Орос Украины дайн, Хятадын Ковидын эсрэг бодлого, түүнтэй холбогдох хязгаарлалтууд, цаашлаад өндөр инфляц зэрэг болно.

Дэлхийн засгийн газрын өрийн өсөлтийн хэмжээ



Эх сурвалж: OYBC

Эдийн засгийн өсөлт муу, өндөр инфляцын дарамттай зэрэгцээд улс орнуудад өрийн дарамт үүсээд буй. Ковидын дараах эдийн засгийг сэргээх зорилготой хэрэгжүүлсэн төсвийн тэлэх бодлого нь төсвийн зардлыг ихэсгэж, энэ нь эргээд засгийн газрын өрийн хэмжээ ихсэх шалтгаан болжээ. Дэлхийн улсуудын засгийн газрын дундаж ДНБ-д эзлэх өрийн хэмжээ 2020 онд өмнөх оноос 20 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь санхүүгийн хямралын дараах хамгийн өндөр өсөлт бөгөөд газрын тосны 2-р хямрал, АНУ-н 1990-ээд оны эдийн засгийн хямрал, 2000 оны Азийн санхүүгийн зэх эзэлийн хямралын үеүдэд мөн ийнхүү ажиглагдаж байжээ.

СТАГФЛЯЦЫН ҮЗЭГДЭЛ

Дайны нөхцөл байдалтай холбоотойгоор сүүлийн үед стагфляц гэх нэр томъёолол ихээр ашиглагдах болжээ. Инфляцтай төстэй стагфляц гэх үг нь Англиар stagnation+inflation гэх хоёр үгээс бүрдсэн буюу орчуулбал эдийн засгийн гацалттай инфляц юм. Товчоор бол инфляц өндөр, эдийн засгийн өсөлт гацсан, ажилгүйдэл ихтэй байх үеийг хэлнэ.



Олон улсын байгууллагуудын стагфляцын талаарх байр суурь:

- Дэлхийн банкны мэдээлснээр стагфляцын үзэгдэл одоогоор ажиглагдаж эхлээгүй байгаа ч тун удахгүй зөвхөн буурай гэлтгүй хөгжиж буй, хөгжсөн эсэхээс үл хамааран дэлхийн өнцөг булан бүрд явагдана гэж үзжээ.

(Stagflation risk rises amid sharp slowdown in growth, Worldbank, 2022.06.07)

- Форбс сэтгүүлд дурдсанаар яг одоогийн нөхцөл байдалд стагфляцын үзэгдэл бүрэн дүүрэн ажиглагдаагүй ч мөнгөний бодлогын хугацааны хоцролттой нөлөөгөөр инфляцын түвшин онилсон түвшинд хүрэхгүй удсанаар яваандаа стагфляцын үзэгдэл ажиглагдана гэжээ.


(Stagflation: Causes and when it will come, Forbes, 2022.06.28)

- Европын холбооны банкнаас стагфляцын үзэгдэл эрт, орой хэзээ нэгэн цагт бий болно. Хамгийн чухал асуулт нь “Богино хугацаанд бид стагфляциас гарч чадах уу, эсвэл урт хугацааны үргэлжилсэн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд байсаар байх уу?” юм. *(Does the private sector foresee a stagflation episode?, European Central Bank, 2022.04.27)*
- Файнейншл таймс-н үзсэнээр стагфляцын үзэгдэл дэлхий даяар дахин ажиглагдаж байна. Ковид болон Орос Украины дайн гэсэн хоёр томоохон шокийн дараа улс орнуудад инфляц хүлээлтийг давж сүүлийн хэдэн арван жилд байгаагүй хамгийн өндөр түвшиндээ хүрч байхад эдийн засгийн өсөлт хурдацтайгаар буурч байна. Тиймээс энэ нь стагфляцын эхлэл мөн гэж үзжээ. *(The global stagflation shock of 2022: how bad could it get?, Financial Times, 2022.06.08)*

Дээрх олон улсын байгууллага, сэтгүүл дээр дурдсанаар стагфляцын үзэгдэл ажиглагдаж эхэлсэн, ажиглагдаж эхлэх нь ойрын хугацаандаа тодорхой гэж үзсэн байна. Тиймээс бодлого боловсруулагч нарын өмнө тулгарч буй хамгийн том асуудал нь стагфляцаас эдийн засгийг хэт их хямруулахгүйгээр гаргах явдал юм.

Онолын хувьд эдийн засагт нийлүүлэлтийн шок бий болох, үр ашиггүй бодлого явуулах зэргээс шалтгаалан стагфляц бий болдог. Одоогийн дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалд дайн болон Ковидоос шалтгаалсан нийлүүлэлтийн шок, мөн эдийн засгийг сэргээх зорилгоор мөнгө болон төсвийн тэлэх бодлого явуулсан зэрэг нь стагфляц үүсэх үндсэн суурь шалтгаанууд болжээ. Тиймээс хамгийн чухал нь хурдан хугацаанд үр дүнтэй бодлого баримталж стагфляцаас гарах юм.

АНУ-ын бодлогын хүү, сараар, 1954 7р сар-2022 9р сар



Эх сурвалж: Bank of International Settlements

Стагфляц нь сүүлийн үед шинээр гарч буй нэр томъёолол биш билээ. Анх стагфляцын талаарх ойлголт газрын тосны 1, 2-р хямралын дараа гарч байсан бөгөөд тухайн үед бодлогын арга хэрэгсэл маш чухал ач холбогдолтой нь батлагдаж байжээ.


Вьетнамын дайн болон өлсгөлөнг бууруулах хөтөлбөрүүдэд нэлээдгүй мөнгө зарцуулаад байсан АНУ-ын эдийн засагт 1973 онд газрын тосны 1-р хямрал, үргэлжлүүлэн 1979 онд газрын тосны 2-р хямрал тохиолдсон нь стагфляц бий болох суурь шалтгаанууд байв. 1973 онд Саудын Араб болон Израйл хоорондын дайны үед АНУ нь Израйлыг дэмжиж цэрэг армийн туслалцаа үзүүлсээр байсан учраас Саудын Арабаас АНУ-руу газрын тос экспортлоход хориг тогтоожээ. Цаашлаад 1979 оны Ираны хувьсгалын үеэр босогчид Ираны газрын тосны салбарыг сүйрүүлж нийлүүлэлтийн шокийг бий болгож байжээ. Ийнхүү газрын тосны хямралын үеүдэд нийлүүлэлтийн шокоос шалтгаалан газрын тосны үнэ оргил түвшиндээ хүрч байсан.

Тухайн үед уламжлалт эдийн засгийн онолоор хямралыг давж, эдийн засгийг дэмжих зорилгоор сан болон мөнгөний тэлэх бодлогыг хэрэгжүүлсэн ч ажилгүйдэл буурах юм уу, эдийн засаг өсөх хандлага ажиглагдахгүй байв. Бодлогын үр дүнд аль хэдий нь хөөрөгдөөд байсан инфляц улам өндөр түвшинд хүрч байжээ.


Тиймээс 1979 онд Пол Волкерын удирдлага доор АНУ-н Төв Банк нь стагфляцыг давахын тулд мөнгөний хатуу бодлого барьж бодлогын хүүг 19 хувь хүртэл өсгөснөөр эдийн засгийн томоохон 2 хямралын дараа стагфляцаас гарч чаджээ.

Ийнхүү стагфляцын үед эдийн засгийг дэмжих сангийн тэлэх болон мөнгөний зөөлөн бодлого явуулах уламжлалт онолоос илүү инфляцыг бууруулах мөнгөний хатуу бодлого барих нь үр дүнтэй байсан.

Монгол улсын инфляц, ажилгүйдэл, эдийн засгийн өсөлт /2022Q2/




АНУ-н инфляц, ажилгүйдэл, эдийн засгийн өсөлт /2022 оны 2-р улирал/



Эх сурвалж: Дэлхийн Банк, АНУ-н Хөдөлмөрийн Статистикийн Хороо

АНУ болон Монгол улсын хувьд стагфляцын үзэгдэл ажиглагдаж эхэлсэн эсэхийг дээрх графикуудад дүрсэлсэн бөгөөд графикаас харахад Ковид тархсанаас хойш инфляцын түвшин өндөр, ажилгүйдлийн түвшин өссөн, эдийн засаг уналттай байна. Эдийн засгийн өсөлт зарим үед эерэг байгаа ч Ковидын өмнөх үеийн түвшиндээ хүрч чадаагүй байна. Үүнээс бид стагфляцын эрин үе ирж байгааг харж болно. Тиймээс энэхүү эгзэгтэй нөхцөл байдалд бодлого боловсруулагч нар инфляцыг бууруулахын зэрэгцээ эдийн засгийг хөнгөхөн газардуулах хүндхэн даалгавартай тулгараад буй. (IMF, 2022) Ихэнх улсын төв банкнаас баримталж буй бодлого нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж ахин мөнгө, сангийн зөөлөн бодлого явуулахаас илүүтэй мөнгөний хатуу бодлого явуулж бодлогын хүүг эргээд өсгөх байдлаар хөөрөгдөөд буй инфляцыг буулгах юм.

Төв банкуудын бодлогын хүү, 2019M12=100, сараар, 2019 12р сар-2022 7р сар



Эх сурвалж: Bank of International Settlements

Цар тахал гарснаас хойш улс орон бүрийн засгийн газар, төв банкнаас тодорхой хэмжээнд төсөв болон мөнгөний зөөлөн бодлогын арга хэмжээг авч байсан. Үүнтэй холбоотойгоор нийт эрэлт өсөж, энэ нь эргээд инфляцыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих шалтгаан болохоор таамаглагдаж байсан. Эдийн засаг харьцангуй сайжирч, улмаар инфляцыг эргээд буулгах зорилготойгоор ихэнх улс орнууд бодлогын хүүгээ эргээд өсгөх, төсвөөс хэрэгжүүлж байсан татаас тэтгэмжийн хэмжээг багасгах арга хэмжээ аваад байгаа. АНУ-ын хувьд энэ оны 6-р сараас эхлэн бодлогын хүүгээ даруй 0.75 пунктээр нэмэгдүүлж 2.25-2.5 болгосон бол Английн Төв банк маргааш нь хүүгээ 1.25 пунктээр нэмэгдүүлжээ. Харин энэ 9-р сард АНУ ахин бодлогын хүүгээ 0.75 пунктээр нэмэгдүүлж 3.00-3.25 болголоо. Монгол улсын хувьд ч мөн 6-р сараас бодлогын хүүгээ 1 пунктээр дахин нэмэгдүүлж 10 хувьд хүргэсэн бөгөөд 9 сард ахин нэмэгдүүлж 12 хувьд хүргэсэн. Гэсэн хэдий ч дайнтай холбоотойгоор бодлогын үр нөлөө багаар ажиглагдаж улс орнуудад инфляцын түвшин өндөр хэвээр байна.




2

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Бодит ДНБ-ны өсөлт /салбараар/



Эдийн засгийн өсөлтийн түвшин 1-р улиралд -3.8 хувийн бууралттай байсан ч 2-р улирлын статистик мэдээллээр 1.9 хувийн өсөлттэй гарлаа. Энэхүү өсөлтөд ХАА 11.3%, дэд бүтэц 5.2%, харилцаа холбоо 17.0%, худалдааны салбар 10.4 хувийн сэргэлт эергээр нөлөөлсөн бол уул уурхай -28.9% болон тээврийн салбарын -18.9 хувийн бууралт сөргөөр нөлөөлжээ.

2022 оноос эхлэн дотоодын хориг саад суларч бизнесийн үйл ажиллагаа дахин сэргэж эхэлсэнтэй холбоотойгоор уул уурхайн бус салбар болох ХАА болон харилцаа холбоо, худалдааны салбар эерэг өсөлттэй гарчээ. Нөгөө талаас Хятадын одоог хүртэл хэрэгжүүлсээр байгаа “Тэг Ковид” бодлогын нөлөөгөөр Хятадын гол боомтуудын хилийн хорио цээрийн нөхцөл байдал тээвэр ложистикийн асуудлыг үүсгэж тээврийн салбарын бууралтыг мөн цаашлаад хилээр нэвтрэх ачааны тэрэгний тоон бууралт нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулснаар уул уурхайн салбар 1, 2-р улиралд бууралттай байв.

Хэдий эхний 2 улирлын нэгдсэн байдлаар уул уурхайн салбар бууралттай гарсан ч сүүлийн үеийн боомтоор нэвтрэх ачааны тэрэгний тоо нэмэгдэж байгаатай мөн шинэ Таван Толгой төмөр зам нээлтээ хийсэнтэй холбогдон ирэх саруудад эерэг гарах хүлээлттэй байна. Үүнээс шалтгаалан ирэх 3-р улиралд эдийн засгийн өсөлт нэмэгдэх эерэг төлөвтэй байгаа ч хилийн хорио цээр үргэлжлэн явагдах, Орос Украины дайн хурцадмал байдалд орж Оросоос эрчим хүчний бүтээгдэхүүнүүд авах боломжгүй болох, олон улсын зах дээр нийлүүлэлтийн сүлжээний тасалдал үргэлжлэх зэрэг биднээс үл хамаарах гадаад эрсдэлүүд эдийн засгийн өсөлтийг сааруулах магадлалтай.

ИНФЛЯЦ, МӨНГӨНИЙ БОДЛОГО

Инфляцын түвшин, бодлогын хүү



Эх сурвалж: Монгол Банк

Ковид тархсан үеэс эхлэн эдийн засгийг дэмжиж зөөлөн газардуулах зорилгоор ихэнх улс орнууд төсвийн тэлэх болон мөнгөний зөөлөн бодлогыг явуулж нийт эрэлтийг нэмэгдүүлэхийг зорьсон. Эдгээр дэмжих бодлогуудын үр дүнд эдийн засаг Ковидын өмнөх түвшиндээ хүрч сэргэх үзэгдэл ажиглагдсан ч Орос Украины дайны нөхцөл байдал бодлогын цар хүрээг хязгаарлав. Монгол улсын хувьд ч эдийн засгийг дэмжих “10 их наядын хөтөлбөр”, “Цар тахлын хууль” зэрэг Ковидын үед хэрэгжүүлэх олон хууль, төслийг баталсан. Төв банкны зүгээс ч мөнгөний зөөлөн бодлого явуулж бодлогын хүүг 6 хувь хүртэл буулган үе шаттайгаар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн бөгөөд 2021 оны жилийн эцсээр эдийн засаг 2020 оны -4.36 хувийн бууралтаас 2021 онд 1.4 хувийн өсөлттэй гарч чадсан.

Ийнхүү 2021 оноос эхлэн Ковидын дараах эдийн засаг сэргэж Ковидын өмнөх түвшиндээ очих хандлагатай байсан ч 2022 оны эхнээс Орос Украины дайн гарснаар инфляцын дарамтыг нэмэгдүүлж улмаар төсөв мөнгөний бодлогыг хумихад хүргэв. 2021 оны эцсээр хоёр оронтой тоонд шилжиж 13.4 хувьтай байсан инфляцын түвшин дайны нөлөөгөөр 2022 онд улам өсөж 6-р сард 16.1 хувь болов.

Инфляц ийнхүү өндөр түвшинд очиход үндсэн хоёр шалтгаан байв.

- Орос Украины дайнаас шалтгаалан шатахууны үнэ өсөж, энэ нь тээврийн зардал өсөх, цаашлаад эцсийн бараа бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлсөн.
- Олон улс даяар инфляцын түвшин өссөн нь импортын бараа бүтээгдэхүүний үнэ бүхлээрээ өсөх шалтгаан болсон. Монгол улсын хувьд хэрэглээний сагсны гол нэрийн бараа бүтээгдэхүүний дийлэнхийг буюу 54.42 хувийг импортын бараа бүтээгдэхүүнүүд эзэлдэг учраас тэдгээр бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх улсын инфляц өсөх нь манай улсын инфляцид шууд нөлөөлнө.


Тогтмол өсөлттэй байсан инфляц 7-р сараас эхлэн 16.1 хувиас 15.7 хувь, 8-р сард 15.7 хувиас 14.4 хувь болж буурах хандлага ажиглагдаж байна. Инфляцыг бууруулах зорилгоор Төв банкнаас бодлогын хүүг 6 хувиас 10 хувь болгож мөнгөний хатуу бодлого баримталсан нь инфляцыг бууруулахад нөлөөлжээ. Энэ 9-р сард ахин 2 пунктээр нэмэгдүүлж 12 хувь болгосон. Нэг талаас бодлогын хүүний өсөлт инфляцыг бууруулж байгаа бол нөгөө талаас тээвэр логистикийн

хүндрэл багасаж өдөрт тээвэрлэгдэх чингэлгийн тоо өсөж байгаа нь инфляцыг буурахад нөлөөлжээ.

ГАДААД ХУДАЛДАА

Экспортын 90 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлдэг манайх шиг орны хувьд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ экспортод, цаашлаад эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй. Манай улсын гол түүхий эдүүд болох алт, зэс, нүүрсний үнэ 2021 онд улс орнуудын эдийн засагт сэргэлт явагдаж нийт эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор нэмэгджээ. Харин 2022 он гарснаар инфляцыг онилох зорилгоор явуулсан төсөв болон мөнгөний хумих бодлогын үр дүнд нийт эрэлт буурч, эдийн засаг сааралттай байснаар түүхий эдийн үнэ буцаад буурах хандлагатай байна.


Алт болон зэсийн үнэ



Эх сурвалж: Блүүмберг Терминал

Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ оргил үедээ буюу 2021 оны 5 сарын дундуур тонн тутамдаа 10'466 долларт хүрж байжээ. Энэ нь 2020 оны эхээс 86 хувиар өссөн үзүүлэлт байв. Ингээд зэсийн үнэ 2021 оны хагасаас эхлэн аажмаар буурч байсан ч дайны нөлөөгөөр 3 сарын эхээр дахин нэмэгдэж 10'674 долларт хүрсэн байна. Харин алтны үнийн хөөргөдөл зэс, нүүрсний үнийн өсөлтийн хувиас доогуур байсан ч мөн л оргил үедээ 2020 оны эхээс 31 хувиар өсөж кг тутамдаа 2'035.55 долларт хүрж байжээ.

Нүүрсний үнэ



Эх сурвалж: Блүүмберг Терминал

Нүүрсний үнэ 2020 оны эхээр тонн тутамдаа 68.5 доллар байсан ч Ковидын нөлөөгөөр 2021 онд аажмаар өсөж 10 сард тонн тутмын үнэ 270 долларт хүрж оны эхээс үнэ 4 дахин өсөөд байв. Ингээд 2021 оны сүүлээр үнэ буурч эхэлсэн ч 2022 оны эхээс дайн гарсантай холбоотойгоор 3-р сард 440 доллар болж дахин оргил түвшинөөсөө 63 хувиар өслөө. Хэдий нүүрсний үнэ буурах үзэгдэл ажиглагдаж байгаа ч харьцангуй өндөр түвшиндээ хадгалагдсаар байна. Ингээд дайн болон Ковид гэх хоёр том шокийн дараа нүүрсний үнэ 2020 оны эхээс 6.5 дахин нэмэгдсэн байна.

Нүүрсний биет хэмжээ, өсөлтийн хувь




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ өсөж байсан ч, нөгөө талаас нүүрсний экспорт биет хэмжээгээрээ 2021 оны хагасаас эхлэн багасаж эхлэв. Үүнд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь Хятадын Тэг-Ковид бодлоготой холбоотой хилийн хориг саад, хязгаарлалт, тээвэр логиистикийн асуудлууд байв. Хэдий барууны орнуудад Ковидын хязгаарлалт зогсож хилийн хориг саад тавигдсан ч Хятадын хувьд вакцины хамралт бүрэн дуусаагүй байгаагаас ийнхүү хязгаарлалтын арга хэмжээг үргэлжлүүлсээр байна.

Ковидын өмнөх үе буюу 2019 онд нүүрсний жилийн экспорт 36.5 сая тонноос 2021 онд 15.7 сая тонн болж 2.3 дахин буурсан бол 2022 оны эхний 8 сарын байдлаар 14.9 сая тонн байна. Ийнхүү нүүрсний экспорт Хятадын үргэлжлүүлэн барьж байгаа Ковидын эсрэг хилийн хориг саад, хязгаарлалтын арга хэмжээнүүдээс үүдэн Ковидын өмнөх түвшнээс 2-3 дахин доогуур хэвээр хадгалагдахаар байна.

Шинжээчдийн үзэж буйгаар Хятадтай худалдааны түнш болдог улсуудаас гадна Хятад улс нь дотооддоо ч энэхүү Тэг-Ковид бодлогоос шалтгаалсан эдийн засгийн уналт, хямралд ихээхэн өртөж байгаа. Гэсэн хэдий ч Хятадын бодлого боловсруулагчид эдийн засгийн өсөлтөөс илүүтэй Ковидыг дарж авах зорилгыг нэн тэргүүнд тавин ажиллаж байна.

Нүүрс тээвэрт гарч буй өдрийн машины тоо 8-р сарын 2 (өнгө) болон 5 сарын 30 (саарал)-ны байдлаар




Эх сурвалж: УУХҮЯ

Экспортын 90 хувийг бүрдүүлэгч гол гурван түүхий эд болох алт, зэс, нүүрсний үнэ ийнхүү дайны нөлөөгөөр дахин өссөн нь гадаад худалдаанд эергээр нөлөөлсөн ч Хятадын хилийн гол боомтуудын хязгаарлалт үргэлжилсээр байгаа нь хилээр нэвтрэх ачааны тэрэгний тоог бууруулж, энэ нь цаашлаад экспортын биет хэмжээг ихээр бууруулав. Нүүрсний экспортын биет хэмжээ оны эхнээс эхлэн бууралттай гарсан ч 7-р сард 11 хувийн эерэг өсөлттэй гарсан нь хилийн нөхцөл байдал сайжирч байгаатай холбоотой.

Энэ оны 5-р сарын сүүлээр Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги боомтоор нэвтрэх нийт ачааны тэрэгний тоо 519 байсан бол 8 сард энэ тоо 866 болж ойролцоогоор 67 хувиар нэмэгдсэн байна. Ийнхүү сүүлийн саруудад хилээр нэвтрэх ачааны тэрэгний тоо нэмэгдэж байгаа нь нүүрсний экспортын биет хэмжээнд эергээр нөлөөлж цаашлаад экспортын хэмжээ, гадаад худалдааны тэнцлийг нэмэгдүүлж байна.

Гадаад худалдааны тэнцэл




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Гадаад худалдааны тэнцэл 8-р сард 2'178 сая ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 89 хувийн өсөлттэй гарчээ. Экспортын хэмжээ 7'777 сая ам.доллар, импортын хэмжээ 5'600 сая ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 45.89%, 31.66%-иар тус тус өсжээ. Орос Украины дайнаас шалтгаалан дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ оны эхээс 128 хувиар буюу 2 дахин гаруй өссөн. Энэ нь манай улсын нүүрсний экспортыг нэмэгдүүлж, цаашлаад нийт экспорт нэмэгдэхэд ихээхэн нөлөөлсөн бол импортын өсөлтөд эрчим хүчний үнэ өссөн, мөн тээврийн зардал өссөнтэй холбоотойгоор эцсийн бараа бүтээгдэхүүний үнэ өссөн нь нөлөөлөв.


Хэдий нүүрсний үнэ өсөж, экспорт ихэссэн ч нүүрсний биет хэмжээ цар тахлын өмнөх түвшиндээ очиход хол байна. Ковидын өмнөх үе буюу 2019 онд нүүрсний жилийн экспорт 36.5 сая тонноос 2021 онд 15.7 сая тонн болж 2.3 дахин буурсан бол 2022 оны эхний 8 сарын байдлаар 14.9 сая тонн байна. Хэдий нүүрсний биет хэмжээ цар тахлын өмнөх үетэй харьцуулахад доогуур байгаа ч хилээр нэвтрэх ачааны машины тоо өсөж байгаагаас шалтгаалан 2022 оны эхний 8 сарын байдлаар 2021 оны мөн үетэй харьцуулахад 35.3 хувийн өсөлттэй байна.

Төлбөрийн тэнцэл /2022-7р сар/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Гадаад валютын албан нөөц /2022-8р сар/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Төлбөрийн тэнцэл 7-р сарын байдлаар -1'316.9 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Гадаад валютын нөөц он гарснаас хойш тасралтгүй багасаж 8-р сарын байдлаар 2'695.6 тэрбум ам.доллар болж 7-р сараас 183 сая ам.доллороор дахин буурсан байна. Гадаад валютын нөөц ийнхүү багасаж байгаа нь дотоодод хөл хорио, хязгаарлалт суларч бизнесийн идэвхжил явагдан импортын бараа бүтээгдэхүүний эрэлт өссөнтэй холбоотой. Эрэлт өссөнтэй зэрэгцэн импортын ихэнх бараа бүтээгдэхүүний үнэ ихээр өссөн нь импортын барааг үнэтэй болгож валютын гарах урсгалыг нэмэгдүүлж байна. Нөгөө талаас иргэдийн төгрөгт итгэх итгэл буурч байгаа нь доллароор хадгалах хандлагыг ихэсгэж улмаар долларын эрэлтийг нэмэгдүүлж байна. 8-р сарын байдлаар долларын хадгаламж өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өссөн бол төгрөгийн хадгаламж 9.5 хувиар буурчээ.


Гадаад валютын нөөцийн бууралт ханшид дарамт үзүүлж 8-р сард төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3'199.28 болж өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар өсжээ. Таван толгой төмөр зам энэ 9-р сард нээлтээ хийсэн ба ойрын нэг жилдээ багтаж 5-6 сая.тн, мөн ирэх жилүүдэд 50-60 сая.тн нүүрс тээвэрлэх боломжтой учраас гадаад худалдааны нөхцөл байдал сайжирч, валютын орох урсгал дунд хугацаандаа нэмэгдсэнээр ханш тогтворжих хүлээлттэй байна.



3

ЭДИЙН ЗАСГИЙН
САЛБАРУУД

Бодит ДНБ-д эзлэх хувь /Салбараар-2022Q2/




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

УУЛ УУРХАЙ

Манай орон шиг уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай оронд уул уурхайн салбарын өсөлт ДНБ-ний өсөлтөд голлох үүргийг гүйцэтгэдэг. Уул уурхайн салбарын өсөлт түүхий эдийн зах зээлд дээрх үнэ болон экспортлох хэмжээнээс шууд хамааралтай.

Уул уурхайн салбарын борлуулалтын орлогын өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


Уул уурхайн салбарын БДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2020 онд уул уурхайн салбар уналттай байсан ч 2021 онд түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалж өндөр өсөлттэй байв. 2021 оны эхний хагаст зэсийн 83%-ийн үнийн өсөлт, алтны 136%-ийн үнийн өсөлт зэрэг нь уул уурхайн өсөлтийн гол түлхэц болсон. Хэдий үнийн өсөлт өндөр байсан ч 2021 оны 5-р сараас Хятадын “Тэг Ковид” бодлого хэрэгжиж эхэлснээс хилийн хорио саад, хязгаарлалтаас үүдэн экспортын хэмжээ буурч, улмаар орлогын хэмжээ багасжээ. Уул уурхайн салбарын борлуулалтын орлого 2022 оны 2-р улирлаас эхлэн сайжирч өсөх хандлагатай байна. Үүнд үнийн өсөлт, цаашлаад хилээр нэвтрэх ачааны тэрэгний тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор экспортын нийт хэмжээ нэмэгдэж байгаа нь нөлөөлжээ.

Уул уурхайн экспортын орлогод эзлэх хувь /2022-8р сар/



Эх сурвалж: Уул уурхай хүнд үйлдвэрлэлийн яам

2022 оны эхний 8 сарын байдлаар уул уурхайн экспортын орлогод чулуун нүүрсний орлого дийлэнхийг нь эзлэх буюу 54 хувийг эзэлж байгаа бол зэсийн баяжмалын орлого 27 хувь, харин алтны орлого 8 хувийг эзэлж байна.

Уул уурхайн салбарын ирээдүйн өсөлт эдгээр гол 3 түүхий эдийн ирээдүйн үнэ болон ирээдүйн эрэлт, олборлох хэмжээнээс ихээхэн хамаарна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, алтны экспорт:

- 2022 оны эхний 8 сарын байдлаар 3'883.2 сая ам.долларын 14'858.9 мян.тн чулуун нүүрс экспортолсон бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2'590.5 сая ам.доллар буюу 3 дахин, биет хэмжээгээр 3'875.7 мян.тн буюу 35.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин зэсийн баяжмалын экспортын хувьд 1993.36 сая ам.долларын 976.8 мян.тн байсан ба энэ нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 0.61 сая ам.доллар буюу 0.03 хувиар, биет хэмжээгээр 83.45 мян.тн буюу 9.34 хувиар өссөн байна. Эхний 8 сарын байдлаар 591.36 сая ам.долларын 9'949.9 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 252.99 сая ам.доллар буюу 1.8 дахин, биет хэмжээгээр 4'191.29 кг буюу 1.7 дахин тус тус өссөн байна.
- Үнийн хувьд чулуужсан нүүрс тн тутамдаа 280 доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 2.5 дахин өсжээ. Зэсийн хувьд тн тутамдаа 2'096.4 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 4.3 хувийн бууралттай байгаа бол алтны үнэ 59'949.9 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өссөн байна.

Чулуун нүүрсний 90-ээд хувийг бид зөвхөн Хятад улсад экспортлодог ба экспортолсон чулуун нүүрсийг ашиглан ган үйлдвэрлэдэг. Хятадын гангын үйлдвэр дэлхийд тэргүүлдэг бөгөөд жилд 1.2 тэрбум тонн ган үйлдвэрлэх хүчин чадалтай. Тиймээс Хятадын эдийн засгийн нөхцөл байдал ирэх жилүүдэд ямар байх, цаашлаад гангын үйлдвэрлэлийн өсөлтийн хурд зэргээс манай чулуун нүүрсний эрэлт тодорхойлогдоно. Ирээдүйд Хятадын гангын үйлдвэрлэл буурах эрсдэл байгаа ч Орос Украины дайны улмаас барууны орнууд болон зарим азийн орнууд ОХУ-аас импортлох нүүрсний хэмжээндээ хориг тавьснаар нүүрсний үнэ ирэх жилүүдэд дайны нөхцөл байдал сайжрах хүртэл өндөр түвшинд хэвээр хадгалагдах төлөвтэй байна. Мөн олон улс орнууд эрчим хүчний орлох бүтээгдэхүүнээр нүүрсийг ашиглаж эхлээд байна.


Уул уурхайн салбар Хятадын хилийн хориг суларч, үйл ажиллагаа хэвийн явагдаж эхлэх үед бүтэн хүчин чадлаараа ажиллаж, сэргэж эхэлнэ. Ойрын саруудад хилээр нэвтрэх ачааны тэрэгний тоо нэмэгдэж байгаа болон Таван Толгой төмөр зам ашиглалтад орсонтой холбоотойгоор экспортлох хэмжээ нэмэгдэж өсөх хүлээлттэй байна. Оны эцсээр уул уурхайн салбарын өсөлт сөрөг хэвээр байх ч 2023 онд огцом өсөж 13.4 хувийн өсөлттэй байхаар таамаглагдаж байна.

Ойрын ирээдүйд уул уурхайн салбарыг дэмжих томоохон бүтээн байгуулалт ихээр хийгдэж байгаатай холбоотой ирэх жилүүдэд уул уурхайн салбарын өсөлт өндөр байхаар төлөвтэй байна.

ХУДАЛДАА

2022 оны 2-р улирлын байдлаар уул уурхайн салбарын өсөлт муу байсан ч уул уурхайн бус салбарын сэргэлт 1.9 хувийн эдийн засгийн өсөлтийг бий болгов. Уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай манай орны хувьд уул уурхайн бус салбарын өсөлт их байгаа нь эерэг мэдээ байлаа. Хэдий уул уурхайн салбар эдийн засгийн тэргүүлэгч салбар хэдий ч цар тахлын үед уналттай байснаас худалдааны салбарын өсөлт 2022 оны 1,2-р улиралд дотоод эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой байв. 2022 оны 2-р улирлын байдлаар худалдааны салбарын бодит ДНБ-д эзлэх хувь 10.6 хувь байжээ. Үүнээс гадна худалдааны салбарын эдийн засгийн сэргэлт нь ажилгүйдлийн түвшинд нөлөөлөл өндөртэй. Нийт ажиллагчдын 12 хувь нь худалдааны салбарт ажилладаг бол ердөө 5 хувь нь уул уурхайн салбарт ажилладаг байна. Тиймээс худалдааны салбарын өсөлт хөдөлмөрийн зах зээлд мөн чухал ач холбогдолтойн сацуу нийт эдийн засгийн чадавхад нөлөөлөл өндөртэй.

Худалдааны салбарын БДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Ковидын эсрэг вакцинд иргэдийн дийлэнх нь хамрагдаж, улмаар Ковидын эсрэг дотоодын хорио цээр багассантай холбоотойгоор худалдааны салбар 2021 онд эргэн сэргэж 2022 оны 2-р улирлын байдлаар 10.4 хувийн өсөлттэй гарав.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2021 оноос эхлэн худалдааны салбар сэргэж борлуулалтын орлого өсөж эхэлсэн ба 2022 оны эхнээс өсөлтийн хурд нэмэгджээ. Үүнд дайны нөхцөл байдал, нийлүүлэлтийн сүлжээний тасалдалтай холбоотой импортын бараа бүтээгдэхүүний үнэ өссөн нь нөлөөлсөн байна. Бодит борлуулалтын орлогын хэмжээ бууралттай байж болох ч оруулж ирэх импортын бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн нь цааш нэмүү өртөг шингээж худалдах бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж, энэ нь статистик тоон үзүүлэлтээрээ борлуулалтын орлогыг өсгөсөн харагдаж байна.

Монгол улсад худалдааны салбар уул уурхайн салбарын өсөлтийг даган өсдөг. Учир нь том уул уурхайн машин, техник, тоног төхөөрөмжийн худалдаа салбарын өсөлтөд томоохон үүргийг гүйцэтгэдэг. Уул уурхайн салбар ирэх саруудад сайжрах төлөвтэй байгаа учраас худалдааны салбарын бодит борлуулалтын орлого мөн өсөх хүлээлттэй байна. Цаашлаад хилийн хориг саад намжихын хирээр нийлүүлэлтийн сүлжээний тасалдал багасаж импортын бараа бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэнээр худалдааны салбарын сэргэлт хурдасна.

ҮЙЛЧИЛГЭЭ


2022 оны 2-р улирлын байдлаар бодит ДНБ-д эзлэх үйлчилгээний салбарын хувь хамгийн өндөр буюу 26.1 хувь байв. Энэ ч утгаараа үйлчилгээний салбар эдийн засагт чухал байр суурийг эзэлдэг. Үйлчилгээний салбарын сэргэлт хурдан явагдах нь эдийн засаг сэргэхэд чухал нөлөөтэй бөгөөд энэ нь нийт ажиллах хүчний 50 гаруй хувийг бүрдүүлдэг томоохон салбар билээ.

Үйлчилгээний салбарын борлуулалтын орлогын өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Үйлчилгээний салбарын БДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2020 оны хорио цээрийн хатуу дэглэмтэй үед үйлчилгээний салбар хумигдаж өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад оны эцсээр -2 хувийн бууралттай байв.

2021 онд хэдий эдийн засгийг дэмжих зорилгоор төсвөөс өрх айлыг дэмжиж орлогыг нэмэгдүүлэх бодлого ашиглаж байсан ч бодит байдал дээр иргэдийн зардал нэмэгдэхээс илүү хадгаламжийн хэмжээ өссөөр байсан гажуудал ажиглагдсан. Энэ нь тодорхойгүй байдлаас үүдэн иргэдийн дунд эрсдэлгүйгээр хадгаламжид мөнгөө байршуулах эрэлт их байсантай холбоотой. Нөгөө талаас Ковидын хугацаанд иргэд гадуур зарлага гаргах шаардлагагүйгээр амьдарч дассан учраас дотоодод үйлчилгээний салбар нээгдсэн ч иргэдийн хувьд гэртээ байхыг илүүд үзэж нийт эрэлт бууралттай хэвээр байв. Ингээд хөл хорио цуцлагдаж зайнаас сурах, ажиллах явц багассантай холбоотойгоор ард иргэд эргээд хэвийн амьдралдаа шилжиж 2021 оны эцсээр үйлчилгээний салбарын өсөлт 5 хувьтай өндөр гарав.

2022 оны хагас хүртэл Орос Украины дайны нөхцөл байдлаас үл хамааран дотоодод үйлчилгээ, үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байснаас үйлчилгээний салбар 4 хувийн өсөлттэй гарсан байна.

Орос Украины дайны нөлөөгөөр инфляц өндөр түвшинд хадгалагдаж байгаагаас шалтгаалан төв банкнаас мөнгөний хатуу бодлогыг баримталж бодлогын хүүг 12 хувь болтол өсгөсөн. Ойрын хугацаанд бодлогын хүүг дахин өсгөх хандлагатай байгаа учраас ирээдүйд зах зээлд мөнгөний эргэлт хомс байна. Үүнээс шалтгаалан нийт эрэлт дараа жил доогуур байх төлөвтэй байгаан улмаас үйлчилгээний салбарын өсөлт оны эцэст саарч 3.2 хувь болох хандлагатай байна.


Үүнээс гадна энэ оны сүүлч хүртэл “Цар тахлын үеийн хууль”-д зааснаар “Ипотекийн зээл”-ийн төлөгдөх хугацааг хойшлуулсан бол ирэх жилүүдээс энгийн горимд шилжиж, өрх айлууд ипотекийн зээлээ төлж эхэлснээр өрхийн зарлагыг нэмэгдүүлнэ. Тиймээс өрхийн зарлагын өсөлт бусад бараа үйлчилгээнд зарцуулах орлогыг багасгаснаар үйлчилгээний салбарын өсөлтийн хувь мөн оны эцэст саарах төлөвтэй байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ

Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж зэрэг багтана. Үйлдвэрлэлийн салбар уул уурхай олборлолтын салбарын өсөлтийг дагаж 2017-18 онд 20 хувийн өсөлттэй байсан ч цар тахлын үеийн нийлүүлэлтийн тасалдал, хилийн хориг саадаас шалтгаалан 2020 онд буурч -1 хувьд хүрэв. Цаашлаад 2021 онд “10 их наяд”-ын хөтөлбөр хэрэгжиж цар тахлын шокод ихээр өртсөн жижиг дунд үйлдвэрлэгч нарыг дэмжих зээл гаргаснаар үйлдвэрлэлийг дэмжиж 2021 онд үйлдвэрлэлийн салбар огцом өсөлттэй байв.


2022 оны эхнээс дахин үйлдвэрлэлийн салбар унаж эхэлсэн нь Орос Украинаас шалтгаалсан шатахууны үнийн өсөлт, цаашлаад тээврийн зардал, импортын зардлаас хамаарсан үйлдвэрлэлийн зардал өссөнтэй холбоотой байв. Үйлдвэрлэлийн зардал өссөнөөр үйлдвэрлэлийн хэмжээ 1-р улиралд буурсан ч 2-р улиралд эргэн өсөх хандлагатай байна. Хятадын гол боомтуудаар нэвтрэх ачааны машины тоо өсөж байгаа нь экспортын хэмжээг нэмэгдүүлж уул уурхайн салбарын өсөлтийг дэмжиж байна. Уул уурхайн өсөлтийг даган үйлдвэрлэлийн салбар мөн 2-р улиралд өсөх хандлагатай байна.

Үйлдвэрлэлийн салбарын борлуулалтын орлогын өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Үйлдвэрлэлийн салбарын БДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Ирэх онуудад уул уурхайн салбарын өсөлт эерэг хүлээлттэй байгаа учраас уул уурхайн салбарын өсөлтийг дагаад үйлдвэрлэлийн салбарын өсөлт мөн нэмэгдэх төлөвтэй байна. Хэдий 2022 онд үйлдвэрлэлийн салбарын өсөлт сөрөг байгаа ч 2022 оны эцэст бууралтын хурд саарч 2023 онд 7.2 хувийн эерэг өсөлттэй байхаар таамаглагдаж байна. Үүнд мөн “Шинэ сэргэлт”-ийн бодлогын нэгээр аж үйлдвэржилтийн сэргэлтийг тодотгож ажиллах төлөвлөгөөтэй байгаа нь эерэг нөлөө үзүүлнэ.

БАРИЛГА


2021 онд хилийн хориг саадаас шалтгаалан нийлүүлэлтийн тасалдал үүсэж, улмаар барилгын материалын үнэ өссөн. Барилгын материалын үнийн өсөлтийг дагаад барилга, орон сууцны үнэ мөн огцом өссөн. 2021 оны дунд хүртэл барилгын салбарын борлуулалтын орлого буурах хандлагатай байсан ч 2021 оны 1-р хагас жилээс 2022 оны 1-р хагас жил хүртэл өссөн байна. 2021 оны хагасаас эхлэн Хятадад “Тэг Ковид” бодлого хэрэгжиж эхэлсэн нь хилийн хориг саадыг чангатгаж ийнхүү түүхий эдийн үнэ нэмэгдэх, цаашлаад барилга, орон сууцны үнэ нэмэгдэх шалтгаан болжээ. 2022 оноос үнийн хөөргөдөл намжиж хэвийн байдалд орох хүлээлттэй байсан ч Орос Украины дайны уршгаар өсөөд байсан барилгын материалын үнэ дахин хэд дахин нэмэгдэж өсжээ.

2020 оны жилийн эцэстэй харьцуулахад 2021 онд өргөн хэрэглэгддэг 20 бараа материалын үнэ дунджаар 35 хувиар өсжээ. Хэдий зарим бараа материалыг дотооддоо үйлдвэрлэдэг ч импортын бараа бүтээгдэхүүнээс хамааралтай байсаар байгаа нь дэлхийн зэх зээл дээрх үнийн хэлбэлзэлд барилгын салбар эмзэг хэвээр байхад нөлөөлж байна.

2021 оны 4-р улиралд захиалга авч буй орон сууцны 1 м.кв-ын дундаж үнэ 3'258'853 төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 3.06%, өмнөх оны мөн улирлаас 19.13% өссөн үзүүлэлттэй байгаа юм. (Тэнхлэг Зууч, 2022)


2022 онд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр нийт 1335 төсөл хөтөлбөр, арга хэмжээ, барилга байгууламжийг 2'137.0 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан байна. Тэгсэн хэдий ч үргэлжлэн өсөж буй барилгын материалын үнээс шалтгаалан төсвийн санхүүжилт баригдах барилга, байгууламжийнхаа үнэд хүрэхгүй, төлөвлөсөн хэмжээндээ хүрч ажиллах магадлал муутай байна.

Барилгын салбарын борлуулалтын орлогын өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Барилгын салбарын БДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Ирээдүйд барилгын салбарын өсөлт эерэг гарах хүлээлттэй байна. 2022 оны эцэст -2 хувийн бууралттай байх ч 2023 онд хилийн нөхцөл байдал сайжрахын хэрээр өсөлт нэмэгдэж 15 хувьд хүрэх таамаглалтай байна.


Хилийн хориг саад багасаж нийлүүлэлтийн тасалдал арилахын хэрээр нэг талаас барилгын материалын үнэ багасаж, нөгөө талаас мөнгөний хатуу бодлогын үндсэн дээр зах зээл дээрх мөнгөний хэмжээ бага байгаагаас ипотекийн зээлийн гаргалт муу байгаа нь байрны эрэлт багасаж орон сууцны үнэ буурах суурь нөхцөлийг хангана. Гэсэн хэдий ч богино хугацаандаа “10 их наяд хөтөлбөр”-ийн хүрээнд ипотекийн зээлийн олголт бүрэн хэрэгжиж дуусаагүй байгаа болон ойрын хугацаанд барилгын материалын үнэ буурах хандлага ажиглагдахгүй байгаагаас орон сууцны үнэ богино хугацаандаа эргэн буурахааргүй байна. Мөн зээл хумигдаснаас шинэ төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт буурч барилгын нийлүүлэлт саарч байгаа нь орон сууцны үнэ өндөр хэвээр хадгалагдахад нөлөөлж байна.

ТЭЭВЭР

Цар тахал гарснаар манай улсын тээврийн салбарын хөгжлийн үнэн бодит төрхийг ил болгов. Ковид гарсантай холбогдуулан хилийн хорио цээр чангарснаар боомтуудын хөгжлийн дорой байдлыг ил болгож хил дээр стандартыг хангасан үйл ажиллагаа явуулаагүйн улмаас импортын болон экспортын бараа бүтээгдэхүүн хилээр нэвтрэхэд хүндрэлтэй байв. Хилийн хорио асуудал намжихын хэрээр тээврийн салбарын борлуулалтын орлого өсөж байсан ч Хятадын “Тэг Ковид” бодлого хэрэгжиж эхэлсний улмаас байдал эргээд муудав.


Тээврийн салбарын бууралт эргээд экспортод сөргөөр нөлөөлж 2022 оны эхний хагасад нүүрсний экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр үргэлж доогуур байв. Уул уурхайн салбарыг даган тээврийн салбар хөгждөг жамтай. Ирэх жилүүдэд “Шинэ Сэргэлт” бодлогын дагуу боомтын сэргэлт нь тээврийн салбарыг мөн хөгжихөд тусална. Боомтын сэргэлтийг дагаад тээврийн салбар хөгжиж улмаар тээвэр логиستيкийн асуудал багассанаар экспортын хэмжээ нэмэгдэнэ. Тиймээс ирэх жилүүдэд тээврийн салбарын өсөлт эерэг гарах хүлээлттэй байна.

Тээврийн салбарын борлуулалтын орлогын өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Тээврийн салбарын БДНБ-ний өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2022 оны төсвийн төлөвлөгөөнд тусгаснаар авто замын хөгжил, дэд бүтцэд түлхүү хөрөнгө оруулах төлөвтэй байгаа ба түгжрэлийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд авто замын олон шинэчлэлт өөрчлөлт мөн хийгдэхээр байна. Эдгээр шийдвэрүүд нь ирэх жилүүдэд уул уурхайн салбарын өсөлттэй зэрэгцэн тээврийн салбарын өсөлтөд эергээр нөлөөлнө.

/Тээврийн салбарын дэлгэрэнгүй мэдээллийг 38-р хуудаснаас авна уу/



4

ИРЭЭДҮЙН
ХҮЛЭЭЛТ

СУУРЬ ТААМАГЛАЛУУД

Орос Украины дайны нөлөөгөөр олон улсад тодорхойгүй байдал нэмэгдээд буй. Цар тахлын нөлөө арилж дуусаагүй байхад дахин шок болж орж ирсэн дайны нөхцөл байдал дэлхийд санхүүгийн хямрал, инфляцын дарамт, эдийн засгийн бууралтыг авчирлаа. Дэлхий даяар орлогын түвшнээс үл хамааран инфляц өндөр, эдийн засгийн өсөлт удаашралтай байгаа нь биднийг стагфляц руу хөтөлж байна. Ихэнх оронд инфляцыг онилох зорилгоор эдийн засгийн хумих бодлогыг явуулж эхэлсэн бөгөөд энэ нь эдийн засгийг зөөлөн газардах боломжийг багасгаж байна.

Тиймээс оны эцэс хүртэл дэлхий даяар эдийн засгийн өсөлт өндөр байхгүй бөгөөд 2023 онд ч энэхүү нөхцөл байдал үргэлжлэх төлөвтэй байна.


Монгол улсын эдийн засгийн тамир тэнхээ ирэх жилүүдэд хэр байх нь уул уурхайн салбарын өсөлт, хөрөнгө оруулалт, бондын дахин санхүүжилтийн бололцоо, хүрэлцээнээс шууд хамааралтай. Дайны нөхцөл байдлаас шалтгаалсан түүхий эдийн үнийн өсөлт манай орон шиг түүхий эдийн экспортоос ихээхэн хамаардаг улсын хувьд эерэг мэдээ болж байгаа ч энэ байдал удаан үргэлжлэх төлөвгүй байна. Нэг талаас түүхий эдийн үнэ, нөгөө талаас экспортын биет хэмжээ хэр байхаас эдийн засгийн өсөлт ихээхэн хамаардаг учир хамгийн том худалдааны түнш орон болох Хятадын эдийн засаг, хилийн хориг саадын нөхцөл байдал ирэх жилүүдэд манай орны эдийн засгийн нөхцөл байдалд шууд нөлөөлнө.

Эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзээд ирэх жилүүдэд Монгол улсын эдийн засгийн өсөлтөд гаднаас нөлөөлөгч хамгийн том дөрвөн хүчин зүйлсийг авч үзье.

1. Орос Украины дайны нөхцөл байдал


Орос Украины дайны нөхцөл байдал урт хугацаандаа үргэлжлэх төлөвтэй байна. Ирэх жилүүдэд дайн бүрэн дуусахгүй ч дайны шок буурч хэт хөөрөгдсөн түүхий эдийн үнэ аажмаар буурах хандлагатай байна.

Нүүрсний үнийн таамаглал



Эх сурвалж: Блүүмберг Терминал

Зэс, алтны үнийн таамаглал



Эх сурвалж: Блүүмберг Терминал

Нүүрсний үнэ ирэх жилүүдэд буурах төлөвтэй байгаа бол зэсийн үнэ харьцангуй өндөр түвшиндээ хадгалагдах төлөвтэй байна. Гол экспортлогч түүхий эдүүдийн үнэ буурах төлөвтэй байгаа нь эдийн засагт муугаар нөлөөлөх ч нөгөө талаас газрын тосны үнэ буурч, энэ нь импортын бараа бүтээгдэхүүний үнийг бууруулснаар инфляцын дарамт буурч, эдийн засгийн өсөлт явагдахад эергээр нөлөөлнө.

2. Хятадын “Тэг Ковид” бодлогын үргэлжлэх хугацаа

2021 оны 5 сараас эхэлсэн Хятадын “Тэг Ковид” бодлого нь худалдааны гол түнш улсуудаас гадна Хятад улсдаа мөн эдийн засгийн хохиролтой байгаа учраас энэхүү бодлогыг 2022 ондоо амжин зогсооно гэж таамаглаж байна. Энэ оны 10-р сард Хятадын “Намын их хурал” болох бөгөөд хурал явагдсаны дараа хилийн нөхцөл байдал сайжрах төлөвтэй байна.

МЕГА ТӨСЛҮҮД

3. Тавантолгой төмөр зам ашиглалтад орох-

Тавантолгой төмөр зам ашиглалтад орсноор эхний жилдээ 5-6 сая.тн нүүрс тээвэрлэх боломжтой. Бүрэн ашиглалтад орсноор жилд 53 сая.тн нүүрс тээвэрлэх боломжтой болно. Энэ оны 9-р сараас нээлтээ хийсэн “Таван толгой төмөр зам”-ын төслийг 2023 онд бүрэн ашиглалтад орно гэж үзлээ. Ашиглалтад орсны дараагаас нүүрсний экспортод томоохон үүргийг гүйцэтгэх ба энэ нь эдийн засагт эерэгээр нөлөөлөхөөр таамаглав.


4. Оюутолгойн “Зэсийн далд уурхайн баяжмал”-н төсөл хэрэгжиж эхлэх-

Энэхүү төсөл хэрэгжсэнээр илүү зэсийн агууламж өндөртэй зэсийг олборлох болно. Ингэснээр олон улсын зах зээлд агууламж өндөртэй учраас өндөр үнээр борлуулагдаж нийт зэсийн экспорт нэмэгдэх боломжтой. “Рио Тинто”-н захирлын хэлж буйгаар Оюутолгой төсөл нь 2023 оны 1-р улиралд бүрэн ашиглалтад орох төлөвтэй байна. Суурь таамаглал дээр 2023 оны 2-р улирлаас бүрэн ашиглалтад орно гэж үзсэн.

Дээрх дөрвөн гадаад хүчин зүйлсийг таамаглал хийх загвартаа авч үзсэний эцэст оны эцсээр болон ирэх онд эдийн засгийн өсөлт, инфляц, ханшийн түвшинг таамагласан.

ИНФЛЯЦ

Инфляцын таамаглал



Эх сурвалж: Голомт банк, МБ, ОУВС, ДБ, АХБ

Цар тахалтай холбоотой хилийн хориг саад, хязгаарлалт нь газрын тосны үнийг аль хэдий нь хөөрөгдөж тээврийн зардлыг нэмэгдүүлэн инфляцын түвшинг өсгөөд байсан билээ. Орос Украины дайн нөхцөл байдлыг улам хүндрүүлэн газрын тосны үнийг дахин огцом өсгөж, инфляцыг дарамтыг улам нэмэгдүүллээ. Инфляцын дарамт нэмэгдэхийн хэрээр төв банкнуудаас бодлогын хүүг нэмж энэ нь эргээд инфляцыг буулгах хөшүүрэг болж байгаа ч инфляцын бууралт маш аажмаар буюу удаан байна.

АНУ-ын төв банкнаас бодлогын хүүг 2.25-2.5 хувь бүртэл өсгөөд буй, дахин 0.75 пунктээр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд 2023 онд 4 хувь хүртэл өсгөх хүлээлттэй байна.


Голомт банкнаас хийсэн тооцооллын үр дүнд 2022 оны эцсээр инфляцын түвшинг 11.3 байхаар таамаглаж байгаа бол 2023 онд зорилтот түвшиндээ ойртож 6.1 хувь байхаар таамаглав. Бусад томоохон байгууллагын хувьд ч Монголын инфляцын түвшинг энэ ондоо хоёр оронтой тоонд хэвээр хадгалагдахаар таамагласан ба Монгол банкнаас 14.7 хувь, Олон улсын валютын сангаас 14.2 хувь, Дэлхийн Банкнаас 10.5 хувь, Азийн Хөгжлийн Банкнаас харин 14 хувьтай байхаар таамаглажээ. Оны эцсээр инфляцын түвшинг олон улсын байгууллагууд өөр өөрөөр таамаглаж байгаа ч бүгд 2022 оны эцсээр инфляц 2 оронтой тооноос буурахгүй гэдэгт илтгэлтэй байна.

ХАНШ

Орос Украины дайн, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэргээс шалтгаалан импортын бараа бүтээгдэхүүний үнэ ихээр өсөв. Энэ нь эргээд гадаад руу гарах валютын урсгалыг нэмэгдүүлж ханшид дарамт болж байна. 2022 оны 8-р сарын байдлаар гадаад валютын албан нөөцийн хэмжээ 2.6 тэрбум.долларт хүржээ. Энэ нь Ковидын өмнөх түвшнээс 2 дахин багассан тоо юм. Экспортын нийт хэмжээ өмнөх онтой харьцуулахад өсөлттэй байгаа ч нүүрсний экспортын биет хэмжээ эхний 6 сард бууралттай байв. Энэ нь орж ирэх валютын урсгалд сөргөөр нөлөөлсөн ба сүүлийн саруудад нүүрсний экспортын биет хэмжээ ихэсч 7-р сард 11 хувийн өсөлттэй гарсан нь валютын нөөцийг буцаан зузааруулахад эергээр нөлөөлнө.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Эдийн засгийн өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Голомт банк, МБ, ОУВС, ДБ, АХБ

Эдийн засгийн өсөлт оны эцсээр 2.1 хувьд хадгалагдахаар байна. Голчлон нөлөөлж буй хүчин зүйл нь “Тэг Ковид” бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй хилийн хориг саад, импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэг болно. Харин ирэх онд том мега төслүүд бүрэн хүчин чадлаараа хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан эдийн засгийн өсөлт 6.1 хувьд хүрэхээр байна. Бусад олон улсын томоохон байгууллагын хувьд ч 2022 оны эцсээр Монгол улсын эдийн засгийн түвшинг ойролцоогоор 2 хувьд байхаар таамаглажээ.

Монгол банкнаас 2.4 хувь, Олон улсын валютын сангаас 1 хувь, Дэлхийн Банкнаас 2.5 хувь, Азийн хөгжлийн банкнаас мөн 1.9 хувь байхаар таамаглажээ. Цар тахлын дараах үеийн сэргэлт удаан, тогтворгүй байх магадлалтай байна. Харин 2023 онд эдийн засгийн өсөлтийг ойролцоогоор 5.8 хувь байхаар таамаглажээ.

Голомт банкнаас мөн бусад томоохон байгууллагуудаас Монгол улсын эдийн засгийн өсөлтийг 2022 ондоо харьцангуй доогуур хэвээр байх ч 2023 онд өндөр өсөлттэй байхаар таамаглажээ.

ЭДИЙН ЗАСАГТ УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

Ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлт явагдаж таамаглалууд биелэх хүлээлттэй байгаа ч учирч болзошгүй эрсдэлүүд мөн бий.

1. 2022 оны намрын бизнесийн идэвхжилийн үед импортын бүтээгдэхүүний эрэлт өсөх, улмаар ханшийн эрсдэлд орох магадлалтай.

Монголд бизнесийн идэвхжилийн үе 9 сараас эхэлдэг. Орос Украины дайнаас шалтгаалан импортын ихэнх бараа бүтээгдэхүүний үнэ өндөр өсөлттэй байна. Манай орны хувьд үйлдвэрлэгч орон биш учраас үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад гаднаас бараа бүтээгдэхүүн ихээр импортлох шаардлага үүсдэг. Тиймээс бизнесийн идэвхжилийн үед гаднаас үнэтэй бараа бүтээгдэхүүн ихээр импортлох нь гадаад валютын гарах урсгалыг нэмэгдүүлж, улмаар ханш чангарах эрсдэлтэй.

2. Оросын бүх банкныг SWIFT-ээс бүрэн хориглосноор шатахууны хямралд өртөж эдийн засаг хүндхэн байдалд орох эрсдэлтэй.

Одоогоор Европын холбооноос ОХУ-н томоохон 10-н банкныг SWIFT-ээс хорьсон билээ. Энэхүү байдал улам даамжирч ОХУ-н бүх банкныг SWIFT-с хорьсон тохиолдолд Орос улсаас шатахууны

хэрэглээгээ хангадаг манай орны хувьд шатахууны төлбөр тооцоо хийж чадахгүй нөхцөл байдалд орно. Ингэснээр шатахуун Оросоос импортолж чадахгүйн улмаас шатахууны хямралд өртөж Шри Ланка улсын араас орох бодит жишээ болох эрсдэлтэй. Гэсэн хэдий ч Европын Холбооноос Оросын бүх банкныг хорьсон тохиолдолд шатахууны хямралд мөн өртөж эдийн засгийн хүндхэн байдалд орно. Тиймээс бүх банкныг хорих эрсдэл бага байна.

3. 2022, 2023 онд төлөгдөх бондын өрийн төлөлтийг “Гадаад валютын албан нөөц”-д дарамт учруулах, тэгснээр ам.долларын ханш огцом чангарах эрсдэлтэй.

2022 болон 2023 онд Чингис болон Гэрэгэ бондын төлөлтийг хийх ёстой. Үүнээс гадна “Хөгжлийн банк”-ны Евро болон Самурай бондын эргэн төлөлтийг 2023 онд хуваарийн дагуу төлж барагдуулах шаардлагатай бөгөөд хэрэв “Хөгжлийн банк”-аас төлж чадахгүй бол засгийн газраас төлнө. 2021 оны 4-р сарын байдлаар “Гадаад валютын албан нөөц”-н хэмжээ 4.9 тэрбум доллар байсан бол 8-р сард 2.7 тэрбум доллар болж буурчээ. Гэсэн хэдий ч олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч Fitch, S&P, Moody гэх гурван том байгууллагын 2 нь Монгол улсын зээлжих зэрэглэлийг В тогтвортой хэвээр үлдээсэн нь 2022-2023 онуудад төлөгдөх бондуудыг дахин санхүүжүүлэх боломж байгааг илтгэж байна. Тиймээс ирэх жилүүдэд бондыг дахин санхүүжүүлж ханшийн эрсдэл багасах боломжтой ч АНУ-н төв банкны хүү өсөж байгаатай холбогдуулан дахин санхүүжүүлэх бондын хүү өндөр байж зардал ихтэй байх болно.

4. Стагфляц хяналтаас гарч инфляцын түвшин улам өсч, эдийн засгийн өсөлт доогуур түвшинд удаан хугацаанд үргэлжлэх эрсдэлтэй.

Инфляцыг бууруулах зорилгоор төв банкнаас мөнгөний хатуу бодлого баримталж бодлогын хүүг 6 хувиас 12 хувь болтол нэмэгдүүлсэн бол банкны заавал байлгах нөөцийн хэмжээг мөн 6 хувиас 8 хувь хүртэл өсгөжээ. Цаашид мөн өсгөх хандлагатай байгаа учраас инфляцын түвшин дахин ихээр өсөх магадлал бага байна. Гэсэн хэдий ч геополитикийн асуудал, худалдааны дайн, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг олон гадаад хүчин зүйлээс шалтгаалж инфляц цаашид өсөх магадлалтай.

НЭГТГЭЛ

Эдийн засгийн макро үзүүлэлтүүдийн ирээдүйн таамаглал

ҮЗҮҮЛЭЛТ	НЭГЖ	ГҮЙЦЭТГЭЛ			ТААМАГЛАЛ	
		2020	2021	2022 Aug	2022*	2023*
Бодит эдийн засаг						
Бодит ДНБ-ны өсөлт (жилийн) *	%	-4.6%	1.4%	1.9%	2.1%	6.1%
Үйлдвэрлэл	%	3.4%	0.3%	-2.8%	-1.3%	7.2%
Үйлчилгээ	%	-2.0%	4.6%	4.3%	3.2%	5.6%
Барилга	%	-3.2%	-32.7%	-1.7%	2.5%	15.5%
Уул уурхай	%	-9.9%	1.7%	-28.9%	-5.8%	13.4%
Худалдаа	%	-12.5%	9.3%	10.4%	5.3%	8.7%
Тээвэр	%	-18.2%	-16.7%	-18.9%	-6.7%	2.9%
Мөнгөний зах						
Инфляци	%	2.3%	13.4%	14.4%	11.3%	6.1%
Бодлогын хүү	%	6.0%	6.0%	12.0%	14.0%	10.0%
Ам долларын ханш **	₮/\$	2'813.3	2'849.3	3'185.7	3'395.2	3'481.9
Түүхий эдийн зах зээлийн үнэ						
Нүүрс	\$/тонн	62.0	144.0	447.4	263.2	140.0
Зэс	\$/тонн	6'174.6	9'317.4	7'990.8	7'375.0	9'166.7
Алт	\$/трой унц	1'769.5	1'799.8	1'764.1	1'879.2	1'831.3

Тайлбар

*- БДНБ-г тооцохдоо 2015 оны суурийг ашигласан ба 2010 он суурь бүхий БДНБ-с тооцсон өсөлтөөс ялгаатай болно

** - Сарын/жилийн сүүлийн өдрийн ханш

Эх сурвалж

- ҮСХ
- Монголбанк
- ОУВС
- Блүүмберг Терминал
- Эдийн засгийн судалгааны алба, Голомт банк



5

ТЭЭВРИЙН САЛБАРЫН СУДАЛГАА


ХУРААНГУЙ

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал гадаад худалдаа, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, валютын ханшнаас хүчтэй хамааралтай байдагтай маргашгүй. Экспорт, импорт нь улсын тээврийн салбарын хөгжил, нөхцөл байдлаас шууд хамааралтай байдаг бөгөөд далайд гарцгүй манай улсын хувьд авто замын болон төмөр замын салбарын хөгжил, идэвхжил нь эдийн засгийн өсөлт, хөгжлийн урьдач нөхцөл болж байна. Сүүлийн жилүүдэд ковидын болон олон улсын геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан тус салбарт томоохон сорилт, өөрчлөлтүүд бий болж байгаа тул энэ удаад бид тээврийн салбарыг онцлон энэхүү судалгааг хийн танд хүргэж байна.

Тээврийн салбарыг ерөнхийд авч үзвэл нийт ДНБ-ий 4 хувийг эзэлдэг, нийт 61 мянган хүн буюу Монгол улсад хөдөлмөр эрхэлдэг нийт ажилчдын 5.4% нь ажилладаг бөгөөд нийт 2105 компани үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улс хилийн асуудлаар хөрш улсуудтай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон тогтоолын дагуу улсын хилд нийт 39 боомт ажиллахаар тусгасан байдгаас ердийн үед 24 боомт байнгын үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Агаарын замын боомт – 6
- ОХУ-тай хиллэдэг хэсэг – 16
- БНХАУ-тай хиллэдэг хэсэг – 17 байна¹.



Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Монгол улсын засгийн газраас коронавируст халдварт цар тахлын эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөх бууруулах зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого” хэрэгжүүлж байна. Энэхүү бодлогод тусгаснаар 2022 – 2032 онд агаарын тээврийн салбарын хувьд нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх 7 төсөл, Төмөр замын тээврийн салбарт хилийн боомтуудыг холбох, төмөр замын сүлжээ болон төв коридорыг өргөжүүлэх нийт 3118 км төмөр замын 10 төсөл, авто тээврийн хилийн боомтуудын хүчин чадлыг сайжруулах ачаа тээврийн терминал байгуулах 7 төсөл, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох нийт 2698 км авто замын 14 төсөл хэрэгжихээр хүлээгдэж байна. Үүний үр дүнд бүтээн байгуулалттай холбоотой 20 – 30 мянган ажлын байр нэмэгдэх, нийт 13 аймаг төмөр замын дэд бүтэцтэй болж 230 орчим орд газар эдийн засгийн эргэлтэнд орох боломж бий болгож экспортын орлогыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой. Энэ нь цаашлаад экспорт, импортын тэнцвэр өсөх, валютын ханш тэнцвэржих нөлөө үзүүлэх юм.

¹ Эх сурвалж: Хил Хамгаалах Ерөнхий Газар - <http://bpo.gov.mn/>

ТЭЭВРИЙН САЛБАР


2021 оны эцсийн байдлаар **тээврийн орлого: 1,380.7 тэрбум төгрөг** байна. Үүний 766.3 тэрбум төгрөгийг төмөр замын тээвэр, авто замын тээвэр 413.9 тэрбум төгрөг, агаарын тээвэр 200.0 тэрбум төгрөг тус тус бүрдүүлж байна. Харин нөгөө талдаа **тээсэн ачааны хэмжээ 49.3 сая тонн** байгаа бөгөөд энд төмөр замын тээвэр 31.3 сая тонн, авто замын тээвэр 17.9 сая тонн, агаарын тээвэр 6.4 мянган тонн байна.

ТЭЭВРИЙН САЛБАР БА ЭДИЙН ЗАСАГ

Тээврийн салбарын орлого, бүтэц


Тээврийн салбар нь Монгол Улсын нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 4% буюу 846.9 тэрбум төгрөгийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар бүрдүүлсэн байна. Тус салбарын бодит ДНБ-ий жилийн өсөлт 2020 онд 18.2%, 2021 онд 7.3%, 2022 оны хагас жилээр 22.5 хувиар тус тус буурсан байна. Энэ нь ковидын нөлөөнд хүчтэй өртсөнийг илтгэж байна.

Тээврийн салбарын нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь, 2022 оны эхний хагас жил




Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Бодит ДНБ-д эзлэх тээврийн салбарын жилийн өсөлт



Тээврийн салбарын орлого нь гадаад худалдаанаас шууд хамааралтай байдаг. 2022 оны эхний 8 сарын байдлаар экспортын 93% -г уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа бөгөөд нүүрс 17%, зэс 26%, алт 4%-г эзэлж байна. Мөн импортын 37%-г хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 32%-г хэрэглээний бүтээгдэхүүн, 19%-г шатахуун бүрдүүлсэн.

Нийт экспорт, импортын бүтэц



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Нийт тээсэн ачаа 2021 онд 49.2 сая тонн, 2022 оны эхний хагас жилээр 21.9 сая тонн буюу өмнөх онд тээсэн ачааны 45%-д хүрсэн. Нийт тээсэн ачааны 63.5% буюу 12.7 сая тонн нь төмөр зам, 9.2 сая тонн буюу 36.5% нь авто замаар хийгдсэн. Ковидын өмнө буюу 2019 оны эцсээрх тээврийн бүтцийг харвал төмөр замын тээвэр 41% буюу авто замын тээврээс бага хувь эзэлдэг байсан.


ТЭЭВЭРТ ЭЗЛЭХ ХУВЬ	КОВИДЫН ӨМНӨ, 2019 он	КОВИДЫН ДАРАА, 2021 он
Авто замын салбар	59%	63.5%
Төмөр зам	41%	36.5%

Тээсэн ачааны биет хэмжээний өсөлт



2021 онд нийт импорт 6.8 тэрбум ам.долларт хүрсний 55% нь төмөр замаар тээвэрлэгдсэн бол 9.2 тэрбум ам.долларын экспортын 53% нь авто замаар тээвэрлэгдсэн байна.

Гадаад худалдаа тээврийн төрлөөр



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Ковидоос шалтгаалан тээсэн ачаа 2020 онд 13%, 2021 онд 18%-аар тус тус буурсан үзүүлэлттэй гарсан. Энэ нь 2021 оны тээсэн ачааны хэмжээ нь 2017 оны төвшнөөс 4.7 сая тонноор бага байна гэсэн үг юм. 2022 оны хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад тээсэн ачаа 21%-р буурсан байна.


Тээсэн ачааны биет хэмжээний өсөлт



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо


2021 оны эцэст тээврийн салбарын нийт орлого 1,380.7 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний 56% буюу 766 тэрбум төгрөгийг төмөр замын тээвэр, 30% буюу 414 тэрбум төгрөгийг авто замын тээвэр, 14% буюу 200 тэрбум төгрөгийг агаарын тээвэр бүрдүүлсэн байна. Ковидын өмнө буюу 2019 онд тээврийн орлого 2 их наяд төгрөгт хүрч байсан бол 2 жил дараалан буурч 2021 онд 2019 оны 66%-тай тэнцэх хэмжээнд очсон байна..

Тээврийн орлого



Тээврийн орлого улс орнуудын ковидтой тэмцэх, үр нөлөөг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүдтэй холбоотойгоор 2020 онд 25%, 2021 онд 8%-р буурсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22% өссөн байна. 2022 онд тээврийн орлого өссөн нь голчлон авто тээврийн орлогын өсөлтөөс шалтгаалсан. 2022 онд ОХУ-Украины дайнтай холбоотойгоор түүхий эдийн үнийн ханш хэлбэлзэл өндөр байсан нь тээврийн өртгийг улам нэмэгдүүлсэн. Энэ нь тээсэн ачааны хэмжээ буурсан хэдий ч орлого өссөн шалтгаан болсон.


Тээврийн орлогын өсөлт



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Төмөр замын тээвэр 2020 онд өсөлттэй гарсан, 2021 онд түвшнээ хадгалсан буюу өсөлтгүй гарсан бол авто тээврийн орлого 2 жил дараалан 25%-с дээш хувиар буурсан. Хэдийгээр агаарын тээвэр 2021 онд сэргэсэн хэдий ч 2018 оны 45%-д хүрсэн, 2021 оны тээврийн орлого нь 2017 оны түвшнээс доогуур байдалтай байна.

2022 оны эхний хагас жилийн хувьд авто замын тээврийн орлого 35%, агаарын тээврийн орлого 101%-р тус тус өссөн бол төмөр замын тээврийн орлого 3%-р буурсан байна.



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

2021 оны байдлаар ковидтой холбоотой бүх төрлийн тээврийн өртөг болон хугацаа өссөн. Агаарын тээврийн өртөг 109%-р хугацаа 33%-р өссөн бол төмөр замын тээврийн өртөг 14%-р, хугацаа 108%-р өссөн байна.

Тээврийн салбар ба бусад эдийн засгийн салбарын уялдаа холбоо

2019 оны салбар хоорондын тэнцлээс харахад тээврийн салбарын нийт үйлдвэрлэлийн 58% нь завсрын хэрэглээ буюу өртөг, 7%-г цэвэр татвар, 15%-г цалин, 4%-г элэгдэл, 16%-г ашиг болж хуваарилагддаг байна. Тээврийн салбарын үйлдвэрлэлийн 42% нэмэгдэл өртөг байдаг бөгөөд энэ нэмэгдэл өртөг нь ДНБ болдог гэсэн үг юм.

Тээврийн салбарын үйлдвэрлэлийн бүтэц




Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Авто замын тээвэр

Авто замын тээврийн тээсэн ачаа 2019 оноос хойш 3 жил дараалан буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2021 онд авто замаар 17.9 сая тонн ачаа ачсан. Энэ нь 2019 онтой харьцуулахад 2.3 дахин бага үзүүлэлт юм. 2022 оны эхний хагас жилийн байдлаар тээсэн ачааны биет хэмжээ 21%-р буурсан.

Авто замаар тээсэн ачаа




Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Авто замын тээврийн үзүүлэлт 2022 оны 6 сар хүртэл буурсан үзүүлэлттэй байгаа нь 5 сар хүртэл Шивээхүрэн боомт хаалттай байсан, гашуун сухайт боомтын нэвтрэлт маш цөөн буюу 80-400 машин нэвтрэх байсантай холбоотой. Харин сүүлийн хагас жилээс эхлэн хилээр нэвтрэх нүүрсний автомашины тоо өссөн тул тээсэн ачааны хэмжээ жилийн эцсээр өсөлттэй гарах хүлээлттэй байна.

Авто замын ачаа тээврийн 86%-г экспорт, 6%-г импорт, 9%-г дотоод тээвэр эзэлж байна.


Авто замын ачаа тээврийн чиглэл




Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

2021 онд нийт 15.4 сая тонн ачаа авто замаар экспортолсон, үүний 48% нь Гашуунсухайт, 27% нь шивээ хүрэн боомтоор гарсан байна. Харин нөгөө талдаа импортын авто замын ачааны 82%-г Замын-Үүд боомтоор оруулж байна.

Авто замын экспортын ачаа




Авто замын импортын ачаа



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Авто замын тээврийн орлого 413.9 тэрбум төгрөг, 2022 оны хагас жилээр 285 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тээсэн ачааны биет хэмжээ бууралттай байгаа ч 2022 оны эхний хагас жилээр тээврийн орлого 35%-н жилийн өсөлттэй байна.

Тээврийн орлого




Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Авто тээврийн тээсэн ачааг бүтээгдэхүүнээр задлан өмнөх онтой харьцуулбал дараах дүгнэлтүүдэд хүрч болохоор байна. Үүнд:

- Авто замаар тээвэрлэсэн нүүрсний хэмжээ 2021 онд өмнөх оноос 2 дахин өссөн.
- Харин зэсийн баяжмал 21%-р, төмрийн хүдэр 39%-р буурсан.

Тээсэн ачаа, бүтээгдэхүүнээр




Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Төмөр замын тээвэр

2021 онд нийт 31.3 сая тонн ачааг төмөр замаар тээвэрлэсний 40.5% нь дотоодод, 35.2% нь экспорт, 10.7% нь импорт байна. 2021 онд төмөр замын тээсэн дотоод, гадаад ачааны 81.3%-г уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрс 41.6%-г, төмрийн хүдэр 31%-г эзэлж байна. 2015 оноос хойш авч үзэхэд дээрх бүтэц хадгалагдсан.


Төмөр замын тээсэн ачаа, чиглэлээр



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр нь улирлын нөлөө өндөртэй бөгөөд жил бүрийн 1 болон 4-р улиралд өсдөг. Барилгын материалын тээвэр 2, 3-р улиралд өсдөг байна. Төмөр замаар тээсэн ачаа 2021 онд 5% өссөн боловч тээврийн орлого -0.5%-р буурсан байна. 2021 онд барилгын материалын тээвэр хамгийн өндөр буюу 32%-н өсөлт үзүүлсэн. Мөн нүүрсний тээвэр 14%-р өсөж 9.8 сая тоннд хүрэв.


Төмөр замын тээвэр



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

2021 онд төмөр замын тээвэр 766.3 тэрбум төгрөг буюу өмнөх оны төвшинд гарсан бол 2022 оны хагас жилийн байдлаар 325.3 тэрбум төгрөгийн 3%-ний орлоготой ажилласан бөгөөд энэ нь өмнөх оны төвшинд байна. Ачаа тээврийн хэмжээ өссөн ч зорчигч тээвэр 2021 онд огцом буурсантай холбоотой нийт орлогын өсөлт үзүүлээгүй байна.

Төмөр замын тээврийн орлого



Эх сурвалж: Үндсэний статистикийн хороо

Ковидоос өмнөх үед жилд төмөр замаар 2.5-3.0 сая хүн жилд дунджаар тээвэрлэдэг байсан. Ковидтой холбоотойгоор 2020-2021 онд олон улсын зорчигч тээвэр зогсож дотоод зорчигчдын тоо буурсан. 2021 оны зорчигч тээврийн тоо нь ковидын өмнөх үе буюу 2019 оны 12% тай тэнцэх хэмжээнд гарсан.

Дүгнэлт

Ковидоос хойш сүүлийн 3 жилд тээврийн салбарт хүндхэн сорилт тулгарсан нь статистик үзүүлэлтүүдээс тодорхой харагдаж байна. Ялангуяа авто замын тээвэр буюу Монгол улсын ихэнх уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэдэг салбар илүү өртжээ. БНХАУ-ын ковидоос шалтгаалсан хилийн хориг нь тээврийн салбараар дамжин нийт экспортын орлогыг бууруулж, валютын орох урсгалыг багасгасан. 2022 он гарсаар дэлхийн геополитикийн нөхцөл байдалд нөлөө бүхий үйл явдал буюу ОХУ, Украины дайн эхэлсэн нь шатахууны үнийн өсөлтөд нөлөөлснөөр тээврийн үнэ өсөх шалтгаан болжээ. Тээврийн салбарт бий болсон эдгээр асуудлууд нь эдийн засгийн бусад салбаруудад ханш болон тээврийн өртгөөр дамжин нөлөөлж цаашлаад хэрэглээний үнийн өсөлтийг бий болгож байна.

Гэсэн хэдий ч 2022 оны 2-р улирлаас эхлэн нүүрсний тээвэр сэргэн хилээр гарах автомашины тоо өсөх хандлагатай болсон нь 2022 оны сүүлийн хагас жилд нөхцөл байдал чамгүй сайжрах хүлээлтийг бий болгож байна. Мөн ирэх жилүүдэд хүлээгдэж байгаа төмөр замын болон бусад автозамын төслүүд ашиглалтад орсноор эдийн засагт эерэг нөлөөг авчрах боломжийг бий болгож байна.



6

ОНЦЛОХ
БҮТЭЭГДЭХҮҮН,
ҮЙЛЧИЛГЭЭ

ТОГТВОРТОЙ, НОГООН БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

Бизнесийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэм, засаглалын хувьд тогтвортой байдлыг нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй, нөхөн сэргээгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, салбартаа үлгэр жишээ байхыг зорьж буй эрхэм харилцагч танд тогтвортой, ногоон бизнесийн зээлийн бүтээгдэхүүнийг танилцуулж байна.

Тогтвортой санхүүжилт, ногоон бизнесийн зээл	Зээлийн хэмжээ	Зээлийн хугацаа
Хөрөнгө оруулалтын зориулалттай бол	1 тэрбум ₮ хүртэл	84 сар хүртэл
Эргэлтийн хөрөнгийн зориулалттай бол	500 сая ₮ хүртэл	30 сар хүртэл

Ерөнхий шаардлага

- Зээл хүсэгч нь тухайн чиглэлээр сүүлийн 24 сараас доошгүй хугацаанд бизнесээ эрхэлсэн байх
- Банкнаас олгосон Тогтвортой санхүүжилтийг зарцуулах бизнесийн үйл ажиллагааны чиглэл нь Голомт банкны Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хориотой болон анхааруулах үйл ажиллагааны жагсаалтад багтаагүй байх
- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний дагуу тухайлсан салбарын бичиг баримт бүрдүүлсэн байх
- Ногоон шалгуур үзүүлэлтийг биелүүлсэн байх

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй, аль эсвэл эмэгтэй удирдлагатай аж ахуй нэгжүүдийн бараа материал худалдан авах, үйл ажиллагааны ашиг, орлогоо нэмэгдүүлэхэд тань зориулан дараах бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл	Зээлийн хэмжээ	Зээлийн хугацаа
Эргэлтийн хөрөнгийн зориулалттай бол	100 сая ₮ хүртэл	36 сар хүртэл

Ерөнхий шаардлага

- Гүйцэтгэх удирдлага эмэгтэй байх
- Компаний 51-с дээш хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг
- Нийт ажиллагсдын хамгийн багадаа 50 хувь нь эмэгтэйчүүд эзэлдэг байх
- Нөхөрлөл, хоршоо бол 51-с дээш хувь нь эмэгтэйчүүд байх

БАЙГУУЛЛАГЫН КАРТ

Байгууллагын дебит карт

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зардлууд болох хангамж, томилолт, интернет худалдаа зэрэг төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой. Ингэснээр таний байгууллагад жижиг мөнгөн санг ухаалагаар зарцуулах, хянах боломжийг бид олгож байна.

Бүтээгдэхүүний давуу тал

- ОУ-д болон дотоодод хэрэглэх боломжтой
- Нэг картын харилцахад 6 хүртэлхи карт холбох боломжтой
- Төгрөг болон ам.долларын сонголттой

Байгууллагын кредит карт

Байгууллагын удирдлагын зардал, санхүүгийн хэрэглээ, онлайн төлбөр тооцоог гүйцэтгэх, зарцуулалт хянах боломж бүхий зээлийн эрхтэй бизнес картыг санал болгож байна.

- ОУ-д болон дотоодод хэрэглэх боломжтой
- Нэг картын харилцахад 6 хүртэлхи карт холбох боломжтой
- Төгрөг болон ам.долларын сонголттой

КОРПОРАЙТ ДИЖИТАЛ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

И-биллингийн үйлчилгээ

Танай байгууллага үйлчилгээний тогтмол төлбөрөө хэрэглэгчдээсээ хураахдаа Голомт банкны “Дижитал банк”-аар дамжуулж тухай бүр төлүүлэх боломжтой үйлчилгээ юм. Та ердөө и-биллингийн үйлчилгээ хүссэн албан бичгийг өөрт байрлах Голомт банкны салбарт өгснөөр тухайн үйлчилгээг авах боломжтой.

Нөхцөл

Үйлчилгээний шимтгэл	Шимтгэл төлөх зарчим	Бусад
Интернет банк, смарт банк шимтгэлгүй Socialpay: Гүйлгээ тутамд 50₮	Тухайн сарын шимтгэлийг дараа сарын 10-ны өдөр байгууллагын данснаас суутгана.	Гүйлгээний тооноос хамаарч гүйлгээний шимтгэлийг харилцан тохиролцоно.

Цалингийн багц гүйлгээ

Танай байгууллага ажилчдынхаа цалинг цагт нь тавихад асуудал тулгарч байна уу? Хэрэв тийм бол цалингийн болон бусад тогтмол гүйлгээгээ интернет банкны тусгай цэсийг ашиглан багцаар хийх боломжийг санал болгож байна.

Нөхцөл

Үйлчилгээний шимтгэл	Шимтгэл төлөх зарчим	Бусад
20,000₮	Голомт банкны төгрөгийн данс хоорондын гүйлгээ	Харилцагчийн хүсэлтээр доорхи интервалаас сонгоно. 20 сая ₮ хүртэл 20-50 сая ₮ 50 – 100 сая ₮ 100 – 300 сая ₮ 300 – 500 сая ₮ 500-с дээш тохируулна.

Бүрдүүлэх материал

- Цалингийн багц гүйлгээний эрх хүссэн албан бичиг
- Гүйлгээ хийх болон хянах албан тушаалтны мэдээлэл
- Онлайн байнгын үйлчилгээ хүссэн маягт

Данс автоматжуулах үйлчилгээ

Танай байгууллагат борлуулалт эсвэл үйлчилгээний төлбөрийг байгууллагынхаа дансанд ормогц шууд үйлчилгээ үзүүлэх эрх нээх хэрэгцээ шаардлага байдаг уу? Тэгвэл байгууллагын сонгосон дансны орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг гүйлгээ хийгдсэн даруйд байгууллагын системрүү хөрвүүлэх, мэдээлэх үйлчилгээг санал болгож байна.

Үйлчилгээний шимтгэл	Шимтгэл төлөх зарчим	Бусад
Гүйлгээ тутамд 200₮	Сар бүрийн эцэст банкнаас илгээсэн нэхэмжлэлийн дагуу төлөлт хийнэ.	Гүйлгээний тооноос хамаарч гүйлгээний шимтгэлийг харилцан тохиролцоно.

Бүрдүүлэх материал

- Байгууллага үйлчилгээнд хамрагдахыг хүссэн албан бичиг
- Данс автоматжуулах үйлчилгээний өгөгдөл солилцох дүрмийн дагуу шаардлагад нийцсэн программын хөгжүүлэлтийг хийсэн байх

Корпорэйт гэйтвэй

Корпорэйт гэйтвэй үйлчилгээ нь харилцагч байгууллага өөрийн санхүүгийн программ, вэбсайт болон аппликэйшнээр дамжин банкны системтэй шууд холбогдож банкны үйлчилгээ авах боломжтой.

Үйлчилгээний шимтгэл	Шимтгэл төлөх зарчим	Бусад
Гүйлгээ тутамд 100₮-500₮	Сар бүрийн эцэст банкнаас илгээсэн нэхэмжлэлийн дагуу төлөлт хийнэ.	Гүйлгээний тооноос хамаарч гүйлгээний шимтгэлийг харилцан тохиролцоно.

- 24/7 ашиглах боломжтой
- Цаг хугацаа хэмнэнэ
- Үйлдэл автоматжуулах боломжтой
- Хяналтын нэг цэгээс хийх боломжтой
- Байгууллага өөрсдөдөө тохируулан хөгжүүлэлт хийх боломжтой
- Хурдан шуурхай
- Гүйлгээний эрхийн тохиргоог хийх
- Аюулгүй байдал
- Банкны 20 гаруй үйлчилгээг авах боломжтой

DIGITAL - LOYALTY ХӨНГӨЛӨЛТИЙН СҮЛЖЭЭ

Картаар худалдан авалт хийдэг үйлчлүүлэгчдийг урамшуулах, үнэнч худалдан авалтыг бий болгох.

- Үнэнч худалдан авалтыг таних, урамшуулах, тогтоон барих
- Хамгийн шинэлэг үйлчилгээг үйлчлүүлэгчдэдээ санал болгох
- Лоялти сувгийг хэрэглээг байгууллагад таниулах
- Байгууллагын борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх

Давуу тал

- Худалдан авагчдыг татах, борлуулалтын суваг нэмэгдүүлэх боломж
- Банкны Лоялти системийг нэмэлт төлбөргүй ашиглах боломж
- Картын гүйлгээгээр дамжуулж харилцагчийн зан төлөв тодорхойлсон бэлэн анализ авах, шийдвэр гаргалтад ашиглах
- Үнэнч худалдан авалтыг урамшуулах дүрмийг тодорхойлох

Шаардлага

- Голомт банкны Картаар үйлчлэгч байгууллага байх
- Картаар төлбөр тооцоо хийсэн харилцагчдад хөнгөлөлт үзүүлэх
- Хамтын ажиллагааг харилцан сурталчилан таниулах

Байгууллагын банкны газар:

И-мэйл хаяг: corporatebanking@golomtbank.com

Корпорэйт лавлах утас: 7011-7676

Үйлдвэр худалдааны хэлтэс: 7575-1111 (1403)

Бизнес хамтын ажиллагааны хэлтэс: 7575-1111 (1212)

Уул уурхай, дэд бүтцийн хэлтэс: 7575-1111 (1210)

Нөөцийн удирдлагын газар:

И-мэйл хаяг: forex@golomtbank.com

Арилжааны хэлтэс: 7555-3434

Эдийн засгийн судалгааны алба:

И-мэйл хаяг: eru@golomtbank.com

Утас: 7575-1111 (1277)

Хаяг: Голомт банкны Төв байр,
Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол улс

Swift: GLMTMNUB